

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

2020 оны ... дугаар
сарын...-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ 2024 ОН ХҮРТЭЛ БОЛОВСРОНГУЙ
БОЛГОХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийг үндэслэн
Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох
үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

2. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүнээс санаачлах хууль
togtoomjийn төсөлд энэ тогтоол хамаarahгүй.

3. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгагдаагүй
боловч нэн шаардлагатай гэж үзсэн хууль тогтоомжийн төслийг санаачлан
боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлж байхыг Засгийн газар
/У.Хүрэлсүх/-т үүрэг болгосугай.

4.“Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох
үндсэн чиглэл”-ийн биелэлтийг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж
ажиллахыг Засгийн газар / У.Хүрэлсүх /, холбогдох Байнгын хороодын дарга нарт
даалгасугай.

Гарын үсэг